

“АЙ НАН-АА” АМРАГИЙН ДУУ МӨН ҮҮ?

Ж.Болдбаатар (МУИС)

“Ай нан-аа” хэмээх дуунд:

Зүүн ууланд нь зэрэглээ байна хө

Ай Нан-Аа хө хө

Зүглээд очсон чинь үгүй л байна хө

Зүүд нойрондоо хоёулаа байна хө

Ай Нан-Аа хө хө

Зүүдлээд сэрсэн чинь ганцаараа байна хө хэмээх бадагт уйтгар гунигт автан, хэн нэгнийг мөрөөдөж буй утга бууна. Өнгөцхөн харвал, алс хол яваа янаг амрагаа мөрөөдсөн, зүүдэлсэн мэт санаа төрнө. 1990-ээд оны төгсгөл хүртэл энэхүү дууны домгийг тэрлэж буй билэг оюунаар бядуу, гүехэн ухаант би бээр ингэж л ойлгож явлаа.

1997-1998 оны хичээлийн жил юмсан. Монгол Улсын Гавъяат жүжигчин, алдарт дуучин С.Цоодол гуай миний ажлын өрөөгөөр үе үе халамцуухан орж ирнэ. Өвгөн дууч, ардын дуу судлаач сайхь хүмүүн:

- Болд оо. Чи чинь Түшээт хан аймгийн Эрдэнэ Дайчин чин вангийн хүн байх аа. “Ай нан-аа” хэмээх дууны намтар түүхийг мэдэх үү? гэж асуугаад хариулт хэлэхийн зуургүй өөрөө сэтгэл эмзэглэтэл нэг бадаг аялаад:

- Хөөрхий, Ханд ван Бээжинд довтлон очиж, Манж чин улсын хааны зарлигаар хүүгээ цаазлуулсныг мэдэж, нутагтаа буцаж ирээд гүн уй гашууд автан энэхүү дууг зохиож аялсан юм гэнэлээ дурсан ярьж билээ.

Би тухайн үед сонин санаа байна гэж бодоод өнгөрсөн юм. 2004 онд миний шавь, доктор (Ph.D) Р.Оюунбат Монгол бөхийн өргөөнд уран бүтээлийн тоглолтоо хийсэн бүлгээ. Эл тоглолт дээр Монгол Улсын Гавъяат жүжигчин Ж.Нансалмаа “Ай нан-аа” хэмээх дууг ая донжийг олж, ёстой зүрх шимширтэл дуулсан юм. Түүнийг чих тавин сонсож суугаа надад хүүгээ санаж битгэрсэн Ханд ван амилаад ирэх шиг санагдаж байлаа. Энэ цагаас хойш уг дууны домгийг нутгийн хөх өвгөдөөс асууж сураглах болсон юм.

II

Эхлээд “Ай нан-аа” хэмээх дууг зохиох болсон түүхэн улбааг сөхөж үзье. 1904 онд XIII Далай лам Түвдэнжамц Монголчуудтай санаа бодлоо нэгтгэхээр Түвдээс сэм гарч, Монголд иржээ. Ингээд 1904-1905 оны заагаар чин ван

Ханддорж, Дандар агримба нарын урилгаар Дайчин вангийн хүрээнд өвлийг өнгөрөөжээ.

Далай лам Вангийн Хүрээнд өвөлжихдөө Дайчин ван Ханддоржийн дунд хүү Данзанжамцын бурхны ном үзэж, ухаан задарч буйг сонжин мэджээ. Тэрбээр ноёны хүүд чойр, цанидын талаар бага сага юм нэмбэл удахгүй бодь мөрийн зэрэгт хүрч болох нэгэн юм даа гэж бодож, багагүй зүйл хэлж сургаж, ухааруулж байлаа. Нэг өдөр Далай лам:

- Ноёнтон. Таны хөвгүүн овоо зэгсэн ном сурах өнгөтэй юм. Та хүүгийнхээ оюуныг сайн тордох хэрэгтэй дээ гэж зөвлөхөд:

- Багштан минь. Би хүүгээ ариун номын оронд илгээж, Таны ухааны нөмөрт ном үзэж, нүд тайлуулахыг туйлаас хүснэ. Та болгоох ажаамуу гэлээ. Ингээд Далай ламын Монголоос буцах үед Ханд ван хүүгээ дагуулан явуулах болов.

Ханд чин вангийн хатан Сэвжидмаа хүүг нь Далай лам таалан соёрхож, бараа сүүдэртээ багтаах болсонд шүтэн биширч, бахдан баярлавч, балчир хөвгүүнээ алс хол он удтал суулгах болсондоо эхийн сэтгэлээр өрөвдөн хайрлаж, зүрх нь шимширч байлаа.

Ханддорж "Миний хүү хятад, төвд, манж хэлийг хичээнгүйлэн үзэж, төгс эзэмшихийг бодоорой. Манж, хятадын бодлогын далд санааг сайтар тандан мэдэх нь хожим улс Монголд маань хэрэг болно. Гэхдээ хүний газар дуу цөөн, үг хямга явдаг юм шүү" хэмээн хүүдээ сургамжлан захилаа. Сэмжидмаа хатан хүүгийнхээ баруун хацрыг үнсэн, түнтгэр толгойг нь илээд, дөрөөг нь сүүгээр мялаан, сацал өргөн хоцрохдоо хонгор үрээ дахин үнэрлэх хувьгүйгээ яахин ухаарах билээ.

• Далай лам Вангийн Хүрээнээс хөдөлж, олон сар аялсаар Бээжин хотноо хүрэлцэн ирэв. Арван тав, зургаа орчим насны Данзанжамц хүүд замын юм бүхэн, тэр тусмаа Бээжин хот онцгой сонин, гэхдээ Монгол нутаг, төрөлх Булган хангай, Ханжаргалант хайрханаа юу юунаас ч илүү сэтгэл зүрхэндээ тээж, аав, ээж, дүү нараа санагалзан дурсаж, бурхан багш, номин хөх тэнгэртээ залбирч явлаа.

Бээжинд очоод хэд хонотол Далай лам Манж чин улсын эзэн хаанд бараалхах боллоо. Тэрбээр хаантанд бараалхахдаа Чин ван Ханддоржийн хүүг шадар бараа бологчдынхоо тоонд оруулна гэдгээ холбогдох хүмүүстээ хэлж, түүнд зохих зөвшөөрөл авч, хааны ордны ёс журмыг сайтар хэлж өгөхийг даалгажээ. Гэтэл энэ явдал Хүрлэг бэйсийн хатгалгаар чин ван Ханддоржийг гоочлох гэж оролдоод санаа нь бүтээгүй, тэрчлэн халхын нэг тойныг хэт өргөмжилж, биднийг

дорд үзэж, хаанд бараалхуулсангүй гэж дургүйцсэн зарим нэг эрх мэдэл бүхий түвд хүний хорслыг төрүүлжээ. Тэд энэ ялдмыг ашиглан, ордны хаалгач, манж түшмэл нартай хуйвалдаж, хүүг нь егүүтгэх замаар Ханддоржоос хариугаа авах хорон муу санаа өвөрлөжээ. Чингээд ёслолын түшмэлд ихээхэн хээл хахууль атгуулж, түүгээр дамжуулан хаанд бараалхахаар явах замын зэрэглэлийг Данзанжамцад шал эсрэгээр ойлгуулсан байна. Төвдүүдийн өширхөл нь үнэндээ манжийн хааныхны загатнасан газар маажих шиг болсон билээ.

Далай лам шадар бараа бологчдынхоо хамт хааны ордонд залран, намс намс алхалсаар шат өөд өгсөв. Данзанжамц хүү ёслолын түшмэлийн айлдсан ёсоор багшийнхаа араас даган, шар торгон замаар хэд алхтал ордны ёслол-хамгаалалтын албаныхан түүнийг барьж саатуулан үлдээлээ. Хүүг тусгай өрөөнд оруулан нэгэн ихэмсэг түшмэл:

- Чи яасан ёс төргүй, муу үхэр монгол вэ? Ордны ёс жаягийг зөрчсөн хэнийг боловч толгойг нь авах ёстой хэмээн учир зүггүй омогдов.

Айж ширвээтсэн хүү:

- Жа, эрхэм дээдэс минь. Өчигдөр ёслолын түшмэл намайг энэ замаар яваарай хэмээн айлдсан бүлгээ гэв.

Түшмэл:

-Ёслолын түшмэлийг дууд гэв. Нөгөө түшмэлийг орж ирэхэд учрыг хэлтэл:

- Би энэ муу амьтныг шар торгон замаар яв гэж яахин хэлэх билээ. Энэ замаар дээдэс морилох ёстойг би олон жил эл албыг залгуулсны хувьд мэдэлгүй дээ. Энэ боол чинь хүний хэлснийг үл ойлгох мангуу амьтан байх нь гэж тун дээрэнгүй өгүүлээд юу ч болоогүй юм шиг, их түшмэл рүүгээ харж бөхөлзөн ёслоод гараад явчихав. Гүтгүүлсэн хөөрхий хүү юу ч хэлж чадсангүй...

Далай лам Ханд чин вангийн хүүд санаа тавьж хөөцөлдсөн боловч ямар ч нэмэр болсонгүй. Байдал хүндэрч, эгзэгтэй болсныг мэдмэгц их ламтан эцэгт нь хэл өгүүлжээ.

Ханддорж гэрийнхэндээ төрийн алба нийлэхээр яаралтай явах боллоо гэдгээ хэлээд Хүрээ орж, тэндээс өртөөлөн олон хоног давхисаар Бат хаалга орчмоос галт тэргэнд сууж Бээжин хотноо үдэш болсон хойно иржээ.

Ханддорж ван Юн Хэ Гүн сүмд өөрийнхөө хошуунаас сууж буй нэгэн ламынд хоног төөрүүлэв. Манжийн хааны зарлигаар хүүг нь хэдийнээ цаазалсан байлаа. Хаан эл байдлыг чанд нууцлахыг даалгасан боловч, Бээжингийн Монгол зургаанд

Түшээт хан аймгаас жасаалж буй Ханддоржийн ойр дотнын ноёд, түшмэд наагуур цаагуур гүйсээр хүүгийн нь хэрэг бишидсэнийг нэгэнт гадарласан байж. Тэд Дайчин ванд учир явдлыг шууд хэлээгүй ч хашир хүн байдлыг ойлгож, ихээхэн уй гашууд автжээ.

Маргааш өглөө нь Ханддорж дагуул хиа нарын хамт хууль цаазын яам руу очлоо. Тэрбээр энд сайн юм болохгүй гэдгийг мэдэж байлаа. Энэ хэргээр далимдуулж, өөрт нь ихээхэн даралт, шахалт, доромжлол ирнэ гэдгийг ч сэтгэл оюундаа дэнслэн тооцож байв. Дайчин вангийн тархи толгойд гол нь биеэ барих хэрэгтэй, муусайн манж нарт муугаа үзүүлэхгүй юм шүү, монгол төрийн түшээ чухам ямар байдгийг үзүүлэх юмсан гэдэг бодол эргэлдэнэ. Бас ч хүү минь амьд байдаг юм биш байгаа даа гэсэн горьдлого ч тасраагүй л байлаа.

Ханддоржийг нэгэн түшмэл угтан ирж, яамны хүлээн авах өрөөнд оруулав. Түүнийг идээ зассан махир хөлтэй ширээнд урьж суулгалаа. Манж нар вантаныг цай, чихэр, жимсээр дайлан ойр зуурыг хэлэлцэн, үндсэн яриандаа орох янз орж байтал, нэг хүн царан дээр тавьсан бүтээлэгтэй юм оруулж ирж Ханддоржид баривай. Вантан уг зүйлийг авч ширээн дээр тавин хонины толгой, шүүс юм байхдаа гэж санаад хутгаа сугалав. Тэр үед үйлчлэгч бололтой тэр хүн бүтээлгийг сөхлөө, тэгсэн чинь хонгор хайртай үрий нь толгой... Хоромхон зуур Ханддоржийн цээж нь давчдаж, зүрх нь зогсох шиг болов. Тэгснээ юу ч болоогүй юм шиг:

- Өө, энэ чинь та нарын үүц байна, би андуурчээ гээд хутгаа хуйнд нь буцааж хийлээ. Ханддоржийг яаж палхийж сандрахыг нь харж, бие сэтгэл нь хүндэрмэгц "Та цаашид хаан төрдөө үнэнчээр залбирч явбал таарна" хэмээн жаантай тэрсэлбэл ингэдэг юм гэсэн тавласан сануулга өгөхөөр зэхэж байсан түшмэл байдлыг ажиглаад мэл гайхаж, мэгдэн сандрав. Тэр хооронд Ханддорж хүүгийнхээ толгойг хоёр гардан өргөөд гарч явлаа. Үүдэнд хүлээж байсан хоёр хиа нь эзэн ноёноо тосч очоод дагасаар унаа руугаа очиход "Хайран хүү минь" гэж нэг уртаар санаа алдаад, хүүгийнхээ толгойг хоёр хиадаа өглөө. Ийм юм болно гэж зүүдлээ ч үгүй байсан хоёр хий багаас нь мэдэх агь ноёныхоо толгойг хараад цочирдон балмагдаж цурхиран уйллаа. Энэ мөчид ноёнтны нулимс нь нүднийхээ аягыг дүүрч нэг ирснээ эргэж эгшив. Тэгээд:

- Монхор үрээсээ хагацах хичнээн хэцүү ч, Монголоосоо хагацаагүй цагт болно хөө гэж шивнэн хэлээд, мориндоо мордлоо.

Ханд чин ван буудалласан газраа ирж талийгаач хүүдээ зориулж ном уншуулаад, түмэн газрын их Цагаан хэрэм рүү очсоноо гэнэт хилэгнэн догширч, отго жинстэй малгайгаараа газар саван:

- Ар Халхад манж-хятадын шаахай, марал илжигний мөр үлдээхгүй болтол үзэлцэнэ дээ хэмээн андгайлсан гэдэг.

III

Чин ван Ханддорж Их Хүрээнд довтолгон ирж, хүүдээ ном уншуулаад, нутаг руу буцжээ. Тэрбээр шөнө хагасалж ирээд өөрийн багш Дандар агримбынд буужээ. Дагуул хиа нартаа нууц задруулахгүй байх зарлиг буулгаад Бээжинд болсон явдлыг багшдаа нэгд нэгэнгүй айлтгалаа. Ярьж байх явцдаа хэд хэдэн ч удаа нулимс нь цийлэгнэж ирээд эгшиж байв. Дандар агримба энэхүү эмгэнэлт явдлыг сэтгэл эмзэглэж сонсонгоо маань уншин залбирна. Чингээд Ханд ван:

- Өглөө үүрээр мордож, хүүгээ оршуулах уу даа. Эцэг, өвгөдийн шарил орших нутаг-Ханжаргалантын өвөрт тавъя. Эхэд нь хэлээд хэрэггүй байх. Багш Та юу гэж бодож байна гэхэд Дандар агримба судар эргүүлж нас, жилийг тооцоод:

- Ноёнтон Таны хэлж буй зүйл ном ёстой таацан нийцэж байна. Маргааш танай хоёр хиа, миний гарын хоёр хамт талийгаачийг хөдөөлүүлье гэв. Багштан хоёр шавиа дуудаад:

- Маргааш би ноёнтонтой эрт юманд явна. Номхон морь бэлд гэлээ. Тэр хоёр цаг үеийн байдал, өнгө төрх, Манжийн эрх баригчид, хятадуудын цадиггүй явуулга, бодлогыг жигшин шүүмжилж, ярилцаж байгаад дуг хийж, нүдний хор гаргав. Хиа, шавь нар нь эртлэн босч, цай унд, унаа морьдыг бэлэн болгожээ. Ханд ван, Дандар агримба нар дагуулуудынхаа хамт зөөлөн өргүүлсээр Галуут орж ирлээ. Шарилын магнай хэмээх эцэг, өвгөдийн оршсон газар Хан уулын оройд шахуу байх учир хэрэн мацсаар нар нэлээд дээр хөөрөх үед хүрч ирэв. Ханд ван өөрийн эцэг Мижиддоржийн баруун хелийн тушаа доод хэсэгт хүүгийнхээ толгойг оршууллаа. Хиа, шавь нар нь тэг татан, чулуу овоолов. Дандар агримба сан тавин, хойтохыг нь уншлаа. Дараа нь эцэг өвгөдийн шарилд хүндэтгэл үзүүлэв.

Тэд Зүүн түрүүний гол уруудан, Өндөр хөтлийн тушаа гол гатлан Дайчин вангийн хүрээний өмнө зүгээс ноёны өргөөнд хүрч ирлээ. Амар мэнд солимогц Сэвжидмаа хатан хүүгээ асуулаа. Ханд ванд хичнээн хэцүү байсан ч багштайгаа тохиролцсон ёсоор:

- Хүү маань сайн. Далай багшийн нөмөр нөөлөгт эрдэм сайн сурч байна гэж хариулаад хүүгийн явуулсан бэлэг хэмээн боодолтой торго, хоргой, багвартай жимс, чихэр тэргүүтнийг барьлаа. Сэвжидмаа хатан бэлгийг хоёр гардан аваад нулимс унаган:

- Миний муу түнтгэр бор хүү, үр минь Нан-аа минь (хүүгээ багад нь Нан-аа хэмээн өхөөрддөг байсан гэнэ. Ж.Б) Нан-аа минь хэмээн амандаа байн байн үглэж байлаа. Сэвжидмаа хатан унтатлаа хүүгийнхээ тухай шалгаах тоолонд Ханд вангийн зүрх өмрөх шиг болно. Тэрбээр шөнөжин хүүтэйгээ тоглож наадан зүүдлэв. Өглөө эрт босоход Вангийн хүрээний зүүн талын Мээж уул төгсгөл зэрэглээтэн байв. Ханд вангийн толгойд:

“Зүүн ууланд нь зэрэглээ байна хө

Ай Нан-Аа хө хө

Зүглээд очсон чинь үгүй л байна хө

Зүүд нойрондоо хоёулаа байна хө

Ай Нан-Аа хө хө

Зүүдлээд сэрсэн чинь ганцаараа байна хө” хэмээх бадаг орж ирлээ. Вантан номынхоо өргөөнд орж, бийр бэхээ нийлээд энэ санаагаа муутуу цаасан дээр татлан бичиж, нэг шастирын завсар хавчууллаа. Өглөө цай зооглосны дараа Вантан:

- Удтал Хүрээгээ эргэсэнгүй. Мордож хийморио сэргээе гэсээр гарч, Өндөр хөтөл дээр гарав. Түүний сэтгэлд талийгаач хүү нь үргэлж уяатай. Салхи сэвэлзэн, алс урьд Сазанбүрэгийн нуруу зэрэглээтэн дүнхийнэ. Ханд вангийн санаанд өглөөний шүлгийг үргэлжлүүлэх бодол эргэлдсэнээ:

“Урьд ууланд нь зэрэглээ байна хө

Ай Нан-Аа хө хө

Угтаад очсон чинь үгүй л байна хө

Унтах нойрондоо хоёулаа байна хө

Ай Нан-Аа хө хө

Унтаад сэрсэн чинь ганцаараа байна хө гэсэн бадаг хөврөн орж ирлээ.

Дараа нь Ханд ван өвгөн багшийндаа бууж, урьд шөнө хүүгээ зүүдэлснээ, шүлгийн мөр хэрхэн сэтгэлд бууснаа ярьлаа. Дандар агримба гуниг, харуусалд автсан шавийнхаа сэтгэлийг засах санаатай нэг шил ганзай авч өгөхөд Ханд ван

хаш тагшаар гурвантаа хүртэв. Чингээд тэрээр шүлгээ аялгуулж эхэлжээ. Удалгүй ноёнтон ордны дууч, хуурч идэрхэн эрийг дагуулан Булган уулнаа салхилах зуур дууныхаа аялгууг засуулан, “Ай Нан-Аа” хэмээх дуу төрсөн гэдэг. Ханд вангийн зовлон гуниг, хагацлаас төрсөн сайхь дуу ардын дуу болон олонд түгжээ. Ийнхүү “Ай Нан-Аа” бол янаг амрагийн сэдэвтэй дуу бус, эцэг хүн харийнхны гарт хүүгээ алдаж, санан харуусч, гуниглан дурсаж, шүлэглэж аялгуулсан түүхт дуу ажээ.